





### ЦАГААН ДАР ЭХИЙН ТУУЖ

Ум сайн амгалан болтугай.

Эрт Жин<sup>1</sup> улсын цагт, Нантай голын эхэнд Нинчан нэрт балгасанд Гау нэрт баян өвгөн Сартваахи<sup>2</sup> бөлгөө. Түүний хөвүүний нэр нь Үнэнийг өгүүлэгч бөлгөө. Тэр цагт Лянхуа гэрэл нэрт газар Муи нэрт баян Сартваахи бөлгөө. Түүнд бус үр үгүй, гагц охин бөлгөө. Тэр охин нь өнгө сайт маш үзэсгэлэнт, номд ихэд гийсэн, ааль номхон, сэтгэл зөөлөн, чин зориг нь гайхамшигт, нэр нь Нарныгэрэл ажээ.

Тийм нэгэн охиныг сонсоод Гау нэрт баян одоод, гуйн авч, хөвүүндээ гэргий болгож өгвэй. Төдий эр эм хоёул... маш хайрлалдаж, эцэг эх хоёртоо их хүндлэлт ажгуу.

Тийн яван атал нэгэн өдөр Гау нэрт баян, Үнэнийг өгүүлэгч хөвгүүнээ дуудаад сургаж өгүүллүүн: Ая хөвүүн минь, хөгшин хүний сургасан үгийг сонс. Орчлонгийн явдал зүүдэн гилбэлгээн<sup>3</sup> мэт буюу. Төрөх, өвдөх, үхэх, өглөх энэ дөрвөн их далайг яахин гэтлэх бид. Эдүгээ миний олсон эд агуурс, хүн мал, гэр балгасан хийгээд эцэст барагдмуй за. Чи дээд гурван эрдэнэ бурханы үсэгт номуудыг суртагдах хэрэг. Орчлонгийн ноён баян болох бичгүүдийг суртугай. Басхүү хүний есөн эрдмүүдийг суртугай хэрэг буй за. Хөвүүн ээ миний үг зөв болох бөгөөс би бэрх үнийг өгч, багш нарыг хурааж эрдмүүдийг сургая хэмээвэй. Хөвүүн алгаа хамтатгаж, үнэн сүсэг сэтгэлээр хариу өгүүллүүн: Их нигүүлсэгч өвгөн эцэг, эмгэн эх минь таны өгүүлснээр болтугай гэв. Төдий эцэг, эх нь тэр үгийг нь сонсож баясаад, төгс эрдэмт их багш нарыг урин ирүүлж, бэрх үнийг хайрлалгүй өгч, хөвүүнээ сургавай.

Тэр Үнэнийг өгүүлэгч хөвүүн төдөлгүй хамаг эрдмүүдийг гайхамшиг сурвай.

Тийн яван атал Гау нэрт баян Сартваахи цагтаа хүрч үхэв. Түүний хойно улам улмаар машид үгүйрэв. Тэр цагт Жин улсын хаан төрийг барих эрдэмт хүнийг эрнэм хэмээн их бичгийг тэр улсад тунхаг тархаавай. Тийн хэмээхийг бүгдэд сонсвой. Эх нь сонсоод хөвүүндээ өгүүллүүн: Авай минь, тэнгэрийн хөвүүний зарлигийг сонсов уу, чи минь. Сурсан эрдэм билгээ хааны хотод одож үзүүлээсэй. Гурван эрдэнэ үнэн бөгөөс хэр ноён болох мэдээ үгүй. Энэ үгээгүй дутуу явахаас дээр буюу хэмээв. Хөвүүн нь тэр эхээн сургасан үгийг сонсоод өгүүллүүн: Их нигүүлсэгч эх минь ээ, язгуурын баян сайн үгүй болов. Гэргий миний өчүүхэн, намайг хааны хотод одсон хойно чамайг хэн тэжээх хэмээн эс болов. Гэргий нь Нарныгэрэл бас сургаж өгүүллүүн: Нөхөр минь чиний сурсан эрдэм чинь маш их буюу, эдүгээ хааны хотод одож ноён болоод

Эртэхи эцэгт чинь залгамж  
Энэ биед чинь алдар нэр их  
Эх, эм хоёрт чинь ашдийн хүнс буюу хэмээв.

Үнэнийг өгүүлэгч мөн үг өгүүлээд эс болов. Түүний хойно нэгэн айлын суух Жэу нэрт өвгөн ирж Үнэнийг өгүүлэгчид өгүүллүүн: Ай эрдэмт хөвүүн минь ээ ойгоо<sup>4</sup> төөрсөн хөгшин хүний үгийг сонс.

Тэнгэрийн хөвүүн хааны зарлиг нь  
Тэнсэл үгүй төрийг тогтоохын тул  
Төгс эрдэм билиг сурсан хүнийг  
Түүтгэрэл үгүй ноён шагнанам хэмээн сонстов.  
Эдүгээ чиний эрдэм далай мэт  
Энэ учирт үл одох чинь юу буй.  
Эрхэм гурван эрдэнийн адистадаар  
Эзэндээ хайрт хүртэх мэдээ үгүй буюу

Чи үтэр одох зөв буй за хэмээгээд суув. Үнэнийг өгүүлэгч уйлаад хариу өгүүллүүн:

Эцэг мэт өвгөн минь сонс  
Эх минь насанд хүрсэн буюу  
Эм минь өчүүхэн, эд уурс барагдав.  
Эзэн хааны хотод одсоны хойно ялдам

Яван ядах эхийг минь хэн тэтгэх  
Идэх өмсөхийг өгмүй.  
Ил эчнээ зовох жаргахыг хэн өчмүй  
Ямагт миний бие одож үл болох хэмээв.

Жэу өвгөн өгүүлрүүн:

Ай хөвүүн минь ер эх, эмийн тул бүү зов  
Зарах ард боол би өгсүгэй  
Их бага, идэх өмсөх би өгсүгэй  
Авай минь чи одож хэр бээр ноён болоод  
Ашдийн хүнс олж  
Ачит эцэг эхийн  
Ач хариулж нэрээ дэлгэрхүл, сайн бөлгөө хэмээх үг-

сийг Үнэнийг өгүүлэгч сонсоод хэтэрхий бишрэн баясан өгүүл-  
рүүн:

Гийсэн өвгөн асрахуй үнэн бөгөөс  
Хэв хэзээ эцэг минь чи болох буюу

Тийн зөвшөөн тархавай. Тэр Үнэнийг өгүүлэгч хөвүүн  
өөрийн эх, эм хоёртоо тэр өвгөний асрахуй үгсийг дэлгэрэн-  
гүйеэ өгүүдэв. Эх, эм хоёр нь тэр үгийг сонсож баясаад,  
идэх, өмсөх хүнсийг бэлдэж, өдрийн сайныг үзэж, хааны хо-  
тод одохыг завдсанд эх, эм нь өвгөн бүгдээр үдэж, эх нь  
өгүүлрүүн:

Үнэнийг өгүүлэгч ноён мөр үтэр болох болтугай  
Өтөлсөн эх юүгээ санах бөгөөс  
Үтэр буцан янагш ир, авай минь

Нарныгэрэл бас сургаж өгүүлрүүн:

Мэргэн билигт гэрийн эзэн минь  
Мондош үгүй ноён болох болтугай  
Мунасан эх юүгээ санах бөгөөс  
Мятал үгүй янагш ирэн соёрх.

Жэу өвгөн бас сургаж өгүүлрүүн:

Их билигт хөвүүн минь  
Зүдэл үгүй ноён болох болтугай  
Зовсон эх, эм юүгээ санах бөгөөс  
Зориглон үтэр ир, авай минь.

Тийн хэмээн ерөөгөөд, Үнэнийг өгүүлэгч хааны хотын зүг явж очив. Эх, эм Жэу өнгөн өөрийн гэртээ харьж ирэв.

Түүнээс Үнэнийг өгүүлэгч хурднаа одоод дээд хааны хотод хүрвэй. Хүрээд сац хааны хотод орж үзвээс өлдөв зүйл эд таваар ба өмсөх идэх ба эрдэнэсээр дүүрсэн буюу. Орд харш ба ноёд түшмэд ба заан, морин, арслан ба үлэл үгүй чимэгдсэн буюу. Тийн яван атал дээд хааны алтан хаалганы гадна наасан бичиг үзэгдвэй.

Түүтгэрэл үгүй гурван сарын гурван шинэд тэнгэрийн хөвүүн нь төрд, эрдэм билигт хүмүүнийг ноён болгоном гэнэм хэмээв. Үнэнийг өгүүлэгч тэр бичгийг үзээд баясаж бүррүүн. Үнэ өгч хоноод гэр авч суув. Тэр гэрийн эзэн үзээд сац ийн сэтгэрүүн: Энэ хүн өнгө сайт дүр нь ноён баян болох хүн буй за хэмээн хүндэлж асууруун: Ай хүмүүн чи аль газрын хүн буюу. Юунд хэрэгтэй энд ирсэн буй хэмээн асуусанд, Үнэнийг өгүүлэгч өгүүллрүүн: Би Нантай голын эхэнд Нинчан балгаснаа суусан хүн буюу. Хааны зарлигаар эрдэм билигт хүмүүнийг ноён шагнанам гэхэд ирлээ би.

Илт тэр гэрийн эзэн баясаад

Идээ умдаанаар өргөн хүндэлж

Нэгэн сайн гэр сонгож

Исэр дэвсгэр бэлдэж оруулав.

Үнэнийг өгүүлэгч тэр гэрийн эзний архи уугаад

Өөрийн эх, эм юүгээ санаж

Өргөс хатгуулах мэт унтаж эс болов.

Бас гурван сарын гуравны шинэд

Хотод эрдэм билигт хүмүүнийг

Хувьтай дуугийн хаалгаар дамжин.

Хурднаа ноён шагнах яаманд хүрвэй.

Мөнхүү Үнэнийг өгүүлэгч ноён болох цаг хүрсний тул

Мөн тэнгэр нар тусалж

Мун үгүй утгат үгийг

Мандуулан долоон хавцсанд гүрдрэл үгүй бичив.

Бичсэн утгат бичгүүдийг бүрнээр бичгийн ноёнд хүргэвэй. Тэр ноён бичгүүдийг нээж үзээд, олон бичээчийн бичгээс гагц Үнэнийг өгүүлэгчийн эрдмийг сайшаав.

Тэр бичгийн ноён олон бичээчийн бичгүүдийг үзэж, сайн эрдэмт гурван мянган хүн эрдэмтэй гэж ноён талбих гэв. Түүний дотор үлэмж эрдэмт гагц Үнэнийг өгүүлэгч буюу

хэмээн хаанд айлтгав. Хаан маш баясаад зарлиг болруун:  
Ай түшмэд сайд та тийм эрдэмтэй үнэн бөгөөс тэр Үнэнийг  
өгүүлэгчийг миний дотоод яамыг мэдэгч ноён болгогдох их  
хэрэг хэмээв.

Хааны зарлигаар  
Хамаг түшмэд сайнд зөвшөөж  
Хааны дотоод яаманд оруулж  
Халхай<sup>6</sup> их ноён болгов

Тийн яван атал тэр цагт Жин улсын хаанд төрийг  
баригч бас нэгэн Лүгү нэрт их ноён бөлгөө. Тэр Лүгү нэрт  
ноён үр үгүй гагц охин бөлгөө. Үнэнийг өгүүлэгчийг эрдэм  
ихт гэж ноён болсныг сонссод үлиа үгүй хурим бэлтгэж, Үнэ-  
нийг өгүүлэгчийг дуудвай. Үнэнийг өгүүлэгч ирж, Лүгүгийн  
их яаманд оров. Лүгү ноён угтаж гараад, гэртээ оруулж,  
өөрийн ёсоор суусны хойно Лүгү ноён архи барьж өгүүлрүүн:

Дээд сайн заяат буюу чи  
Төгс эрдмийг чинь ухваас  
Тэнсэл үгүй улсаа амгалан болгом  
Тэмдэгтэйеэ сайдын манлай чи болей  
Хөгшин хүн миний ганц охин бөлгөө  
Хөвөө мэргүй<sup>7</sup> арван зургаа наслар.  
Хүр их надад нуган хөвүүн үгүйн тул  
Хүргэн чи бол, чамд өгсүгэй.

Үнэнийг өгүүлэгч үл таалан хариу өгүүлрүүн:

Лүгү ноён чи сонсогтун! Миний гэрт талбиж ирсэн хөг-  
шин эх минь бөлгөө. Салхин газарт талбисан зул унтрах ойр,  
бас өчүүхэнээс учирсан гэргий юүгээ төвчиж, учиргүй бас  
эм авбаас огт муушаах нэрийг талбиж, энэ орчлонд алдарших  
буй за.

Хэтэрхий Лүгү дээд их ноён чи сонс  
Гийсэн нэгэн сайн хүнийг эрж өгвөөс зохьюу  
Хэрэггүй миний муу бие  
Хэтэрхий чиний охин, яахин авах буй гэв.

Лүгү ноён маш хилэгнэж өгүүлрүүн:

Лянхуа мэт үзэсгэлэнт охиныг минь  
Луугаас гарсан муу гуйланч лав бардагнан өгүүлэх  
чинь үнэн буй за

Төдий Үнэнийг өгүүлэгч хариу өгүүлдүүн:

Төрийг баригч их ноён чи  
Түргэнээ бүү уурлагтун  
Доорд миний бие  
Гагц сэтгэлээс өөр үгүй хэмээв.

Аргат Лүгү ноён хуурч өгүүлдүүн:

Авай чи бианг ихт болоод  
Ааль чинь асар цухал буюу  
Надад нуган хөвүүн үгүй тул  
Миний гагц охиныг чи асбаас  
Миний эд таваар улс хийгээд  
Магад чинийх бус хэний буй

Манагаар чиний эх, гэргий хоёрыг авч ирээд хамтаар жаргалдья. Үнэнийг өгүүлэгч тэр үгэнд итгэж, хариу өгүүлдүүн: Их ноён оо, хайрлах чинь үнэн бөгөөс мөн төрүүлсэн эцэгт адил хэмээсэнд Лүгү ноён байсаад их хурим бэлтгэж, үр саднаа хурааж, охиноо Тоонолжингоог засаад Үнэнийг өгүүлэгчид өгвэй.

Хойд одор нийлсэн ёс хэмээн  
Хурим хийж хотол бүгдээр  
Хуран чуулан уун идэн жаргалдав.

Үнэнийг өгүүлэгч хойд гэргий авсан нэгдүгээр зүйл.

\* \* \*

Үнэнийг өгүүлэгчийн язгуурын гэргий Нарныгэрэл нулимсаа асгаруулж өгүүлдүүн:

Эх минь өглэв.  
Өвчнөөр басхүү дарагдав.  
Гэрт юмгүй  
Гэрийн эзэн минь одсоор дөрвөн жил болов.  
Хэр бээр эх минь өвчин хөдөлж үхвээс  
Гээх цаас, барих буянгүй яасугай хэмээн гаслан  
уйлаад

Эх юүгээ дэргэд одоод асууруун:  
Өвчин чинь эмнэж болох буюу хэмээсэнд  
Өвчин минь агсаар байнам

Сэхээ үгүй муу хөвүүний тулд  
Санасаар өвчин олбой би  
Сайн, бэр чи мах олох бөгөөс  
Саарал үгүй гуйж ир, би идсүгэй.

Бэр нь дуугүй гараад гасалж өгүүлрүүн:

Зүдэх цагт бусад хэн бээр мах үл өгмү  
Их онгоц далайд дарвуул хугарсан мэт  
Зовлонг энэ биед минь  
Юуны арга хийж үл болмуй хэмээгээд хүж зул ша-  
тааж, их нигүүлсэгч Хоншим бодьсадваад залбиран өчвэй.

Нүдээр үзэгч их нигүүлсэгч  
Ил эчнээ амьтны зовлонг мэдэгч  
Нүглийн зовлонг хүртсэн энэ биеийг  
Илт бууж аврах болтугай  
Эх минь өвчит болов  
Эр минь одсоор сураггүй  
Эх минь бас маханд дурласанд  
Эдүгээ өдөр олох аргагүйн тулд  
Өөрийн биеийн махыг огтолж өгсүгэй, би  
Огтлоход минь үнэн чин зориг үгүй бөгөөс  
Үхтүгэй, үзэгч их нигүүлсэгч минь ээ

хэмээн хоёр алгаа хамтатгаж мөргөөд:

Хурц хутга барьж  
Хувьт өөрийн мөрний зузаан газраас  
Хурднаа нэгэн хэсэг мах огтолсонд  
Хотол үхэдхийж газарт унавай  
Урссан цус нь булаг мэт болж байв  
Үзэгч Хоншим бодьсадва нигүүлсээд  
Үнэн чин зоригоос ухваас  
Удалгүй яр нь анагаав.  
Эрдэмт Нарныгэрэл махаа  
Элдэвчлэн амталж чанаад  
Эхдээ өргөв.  
Эх нь аваад удалгүй идэв.  
Эх нь өгүүлрүүн:  
Энэ амтат мах идээд  
Өвчин минь хөнгөн болов  
Эрдэмт сайн бэр минь



Бас буй бөгөөс идсүгэй  
Бэр нь биеэ бөхийж хариу өгүүллүүн:  
Барав, мах үгүй бөлгөө

эх нь уурлаад харааж өгүүллүүн:

Би өвчит хүн  
Бядан, мах гуйж авсан нэрийг  
Бэлэн хосноор хүлээж аваад  
Бэрд мэт бэр чи мах хулгай хийж идэх

юу вэ? Чиний мэт ач үгүй бэрийг тэжээж юун тус хэмээн мод барьж элдээд ийн өгүүллүүн: Миний өвчин энэ мах идсээр харин энэгдэв.<sup>8</sup> Миний хөвүүн одохуй цагт магад чамайг над гагцаар орхисны тул муу өшөө барив чи хэмээгээд нарийн дээс авч хүлж элдэхэд төдий асрахуй Жэу өвгөн сонсон, ирж гадна байж сонсвоос эх нь бэр юүгээ харааж өгүүллүүн:

Харин чамайг бэр гэж зарахул  
Харин чи мах хулгай хийж идэх чинь юу вэ?  
Харьтан үүнийг чинь сонсвоос  
Харин хөвүүний минь нэр муу болмуу

Нарныгэрэл харну өгүүлэхийн урьд Жэу өвгөн хаалга өшиглөж орон, их дуугаар өгүүллүүн: Бэр юүгээ ямар гэмд эрүүлэв<sup>9</sup> хэмээн асууваас эх нь өгүүллүүн: Тэжээсэн ач үгүй хөвүүний тул сансаар даашгүй өвчин олбой би хэмээн бэр юүгээ жанчсан шалтгааныг дэлгэрэнгүйгээ өгүүлдвэй. Жэу өвгөн өршөөхүй сэтгэл төрж, хүлсэн дээсийг тайлаад, зөвөөр явах Нарныгэрэлийн гараас хөтөлж, Жэу өвгөн гэртээ авч одоод асууруун: Нарийн шулуун авирт авай минь, чи мах хулгай хийж идсэн чинь үнэн буюу. Нарныгэрэл нулимсаа асгаруулж өгүүллүүн:

Ээ өвгөн чи сонс  
Эр минь одсоор дөрвөн жил болов  
Эх юүгээ тэжээхийн тулд  
Өмссөн зүүснээ цөм худалдаж барав  
Эх минь гэнэт маханд дурласанд  
Эдүгээ надад аргагүйн тул  
Өөрийн махнаас хэсгийг огтолж  
Эхдээ идүүлвэй, би

Иймийг үл мэдэн мах хомс хэмээн элдмү  
Ил өгүүлбээс эхийн минь өвчин нэмэх болмуй

хэмээн эсвж эс өгүүлсэн тэр бөлгөө. Энэ үгийг эхэд минь бүү  
өгүүл ачит өвгөн минь. Жэу өвгөн нулимсаа асгаран өгүүл-  
рүүн:

Аяа хөөрхий  
Ийм бодь сэтгэлт бэрийг  
Эрүүт хулгайчид адил  
Эрүүлэх нь юу вэ  
Эрт ачит нэрийг чихэнд сонссон бөлгөө  
Нүдээр үзсэнгүй бөлгөө  
Эрт Жансан нэрт хөвүүн

Эх юүгээ өвдсөнд загасны мах идье хэмээсэнд Жан-  
сан нэрт хөвүүн дээлээ тайлж, мөсөн дээр хэвтэж, загас эрэх  
цагт лусын хаад түүнийг ухаж, нэгэн их загас өгөв гэлээ.  
Тэр ачаар зуун үед хүртэл жаргав гэлээ. Бас Тайсан хаан  
эх юүгээ өвдсөнд хулс мод тулж, уйлсанд тэнгэр нар чин  
үнэнийг мэдэж, сэтгэлийг нь гэгээн болгов гэлээ. Эвий энэ  
чин сэтгэлийг чинь тэнгэр хайрламуи за хэмээн уйлаад Нар-  
ныгэрэлийг эхийн дэргэд авч очоод ийн өгүүллүүн:

Бэр юүгээ ташаарч элдэв, чи  
Бэрийн махыг идэж эс ханаад  
Бас ясыг нь идье гэж элдэв үү  
Барсан муу гөлтгөр гэж донгодов

Эх нь өгүүллүүн: Тийм бөгөөс надад хутга өгтүгэй. Бэ-  
рийн махыг огтолж үзсүгэй би. Жэу өвгөн бас харааж өгүүл-  
рүүн: Чиний гарын мах огтолсу. Чи үл өвдөх буюу. Эх нь  
өгүүллүүн: Миний гарын мах огтолвоос өвдөх үнэн, бэрийн  
махыг огтолвоос үл өвдөх буюу. Жэу өвгөн өгүүллүүн: Бэ-  
рийн чинь чин зориг үнэнхүү тул их нигүүлсэгчийн адисти-  
даар бэр чинь эс өвдсөн буй за. Эх нь бас хилэгнэж өгүүл-  
рүүн: Ай бэр чиний огтолсон ярыг би үзсүгэй хэмээсэнд эр-  
дэмт Нарныгэрэл баруун гараа үзүүлвээс эл; сорви үгүйн  
тул эх нь их дуугаар инээгээд ийн өгүүллүүн: Чивэлт бэр  
минь чиний хуурсан худал буюу. Чин үнэн бөгөөс чиний ог-  
толсон ярыг хааш одов. Бэр нь зүүн гараа үзүүлвээс яр нь  
үнэн ажээ. Эх үзээд: Бэр юүгээ тэвэрч, уйлаад ийн гаслан  
өгүүллүүн:

Ийм ачит бэрийн махыг идээд  
Эрүүлсэн хилэнцээсээ  
Үүрд надад хүрэх болтугай

Миний энэ зовлонг бие минь, амь минь бат болсон юун.

Ачит бэрийн тэжээсэн ачаар  
Адгуус болж төрөөд чамд унуулж  
Хүчээ өгсүгэй.  
Хэтэрхийсэ тэжээсэн ачгүй хөвүүн минь  
Хэдэн муу нэрийг алдаршвай  
Гэмт буруу явсан чинь

Хэв хэзээ тэнгэр чамайг үзмүй за хэмээн цээжин дүүрээд, уйлж үл чадан амь нь гарав. Нарныгэрэл эх юүгээ татаж үзвээс амнаас хөөс гараад үхэв. Жэү өвгөн авс худалдаж аваад, ясыг нь авсалбай. Нэгэн сайн газар сонгож, ясыг газарт оршуулав. Түүний хойно Нарныгэрэл өдөр шөнөгүй уйлахад, асрахуй сэтгэлт Жэү өвгөн хорьж өгүүллүүн:

Алимад<sup>10</sup> үхсэн хүний тулд  
Асар гашуудаж эдгээх буюу  
Ариун сайхан нүд чинь эвдрүүзэй  
Чиний гэрийн эзэн одсоны хойно  
Чивэлт зуд турхан болж би бас үгүйрэв.  
Чиний эхийн буян хэргийг би мэдье гэв.  
Эрийн чинь одох цагт

Эх, эм хоёрыг чинь би даасугай хэмээн ам авсан бөлгөө. Эд нэгэнт барилдсан үгсийг үүрд надад урвахуй ёсон буюу. Түүний хойно Нарныгэрэлд идэх ба өмсөх ба түлэхийг ихэд хүргэж өгөв. Түүнээс нэгэн хэдэн сар барсны хойно Нарныгэрэл ийн сэтгэрүүн:

Гэмт Үнэнийг өгүүлэгч эр минь  
Гэрээ мартав.  
Хэтэрхий, төрсөн эх юүгээ тэвчив  
Гийсэн энэ Жэү өвгөнийг зовоон атал  
Хэзээ сайн болном, би.  
Эдүгээ би хааны хотод  
Эр юүгээ хойноос одсугай хэмээгээд хааны хотод

одохыг илт өгүүлбэй. Жэү өвгөн хариу өгүүллүүн:

Эрдэмт авай чиний одох зөв  
Эдүгээ гэр барааг чинь би хадгалья

Энэ өчүүхэн мөнгийг авч одоод, өлсөх ундаасах цагт хүнслэн, замд явах цагт ихэд сэрж явтугай. Ягша мэт танхай хүнээ ерд үл ханилтугай. Барсын зүсийг зурж болмуй, барсын ясыг нь зурах бэрх гэлээ. Хүний царайг таньж болмуй, хүний сэтгэлийг ухахуйяа бэрх гэлээ.

Хайран сайхан авирт чи минь  
Гагцаар зорчих цаг чинь болов  
Газар хол шавар ус их  
Халуун хүйтэн их, явган яаж хүрнэм  
Ач үгүй Үнэнийг өгүүлэгч хөвүүнийг  
Алимад эд таваарын тул орж  
Ачит эх юүгээ мартаад  
Асар ийм хилэнцэт хүмүүнийг эс үзвээ, би

хэмээн уйлаад Нарныгэрэлийг үдэж явуулав. Тэндээс Нарныгэрэл эхийн ясны дэргэд хүрч мөргөөд, дээд хааны хотын зүг явав. Жич Нарныгэрэл зам явж ядаад, наран унатар уйлж явсаар нарс мод нэрт ууланд хүрэв. Уулын завд ороод, өвс үгтээж, дэвсгэр хийж, нэгэн чулуу дэрлэн хоноод үүр цайсан хойно явав.

Тийн яван атал илт Нарныгэрэл зовох цаг болсонд нэгэн давааг давж явтал нэгэн бүлэг хулгайч хараад Нарныгэрэлийг барив. Тэр хулгайчийн ноён нь Танху нэрт буюу. Түүний цэрэг арван түмэн тоот буй. Бас Жин улсын хааны төрийг эвдэж явах бөлгөө. Танху ноён Нарныгэрэлийг үзээд баярлаж асууруун: Чи аль газрын хүний эм бэ, энд юу хэрэгтэй ирэв. Нарныгэрэл аюул үгүй хариу өгүүлдүүн: Бие минь Нантай голын эхэнд Нинчан балгасанд суусан буюу. Эр минь хааны хотод одсон бөлгөө. Би үгүйрсний тул амиа тэжээх юмгүй гуйланчлан эр юүгээн дэргэд одох минь буюу хэмээсэнд Танху ноён тэр Нарныгэрэлийг үзээд бахдаж инээгээд өгүүлдүүн:

Би их улсаа тогтоож явнам  
Бишрэлт, хий чулуу хадыг хөдөлгөх тарни буй  
Бид их улсын эзэн болбой  
Биеэс танхийн хатан үгүйн тулд  
Эм чи миний зоригоор болбос  
Эрх өгч, хатан цол өргөө.  
Энэ Жин улсын хааныг дарсны хойно  
Эрхэт болж, бид хоёр жаргалдъя

Бас Нарныгэрэл хариу өгүүлдүүн:

Би үгээгүй хүний ожин бөлгөө

Би хааны цол үл даамуй за

Бие үл чадах буй за

Бишрэлт тарнич Танху ноён чи намайг талбин соёрх.  
Танху ноён өгүүлдүүн: Эм чи бүү цааргал, эрхэнд ортугай,  
хэр бээр эс орвоос чамд муу болмуй. Нарныгэрэл бас хариу  
өгүүлдүүн: Нэг сайн моринд хоёр эмээл үл тохох, нэг сайн  
эм хоёр эрд үл одох. Чи намайг үл талбих бөгөөс чиний илд-  
ний ирэнд үхсүгэй. Танху ноён уурлаж босоод илд сугалж  
их дуугаар зандарч өгүүлдүүн:

Эм чи миний зоригоор эс болбоос

Энэ хурц илдээр чамайг цанчиж

Эрлэг хаанд илгээнэм

Чин зоригт Нарныгэрэл бас өгүүлдүүн: Танху чи төрийг  
тогтоох ноён бус, дарсанд сөгтсөн сармагчин байнам. Танху  
хулгайч чи намайг адахаас бус юу хийх хэмээсэнд Танху  
ноён ихэд хилэгнэж өгүүлдүүн: Энэ эмийг гадна аваачиж, ал  
хэмээсэнд олон хулгайч цар өгүүлдүүн: Энэ эмийг алах бус,  
энэ эмийг засгийн гэр хадгалсан өвгөн эмгэн хоёрт аваачиж  
өгье. Тэдний үг маш уран, арга ихт буюу. Түүнд өгвөөс өдөр  
шөнөгүй уран үгээр аргадваас чиний зарлигаар болмуй. Тан-  
ху ноён зөвшөөж, таны үгсээр болтугай гэв. Төдүй засгийн  
гэр хадгалсан өвгөн, эмгэнийг ирүүлээд ийн өгүүлдүүн: Энэ  
өдөр нэгэн эм олж билээ. Би биедээ авъя гэж энэ эмийн эл-  
дэв. Хатуу үгсээр хэлж эс болов. Та хоёр үүнийг гэртээ авч  
одоод, аргадаж үз. Хэр бээр миний зоригоор болбоос та хоё-  
рыг алт мөнгөөр хангасугай, эс чадваас та хоёрын тэргүүнийг  
авсугай хэмээв. Төдүй өвгөн эмгэн хоёр Нарныгэрэлийг авч  
доод гэртээ оруулж, элдэв зүйл уран үгсээр аргадваас тэр  
Нарныгэрэл чин зориг огсоот бариад, аргадаж эс болов. Тэр  
өвгөн эмгэн хоёр Нарныгэрэлийн чин үнэнийг мэдээд ийн  
зөвлөлдүүн: Энэ ам аргадаж эс болов. Үүний би авч, энэ  
хулгайчийн гараас гаргах аргыг үүсгэе хэмээв. Эмгэн нь зөв  
аргыг хичээж үүсгэ. Өвгөн дээд ноёны дэргэд одоод, сөгдөж  
өгүүлдүүн: Ай их ноён миний үгийг сонс, тэр эмийн үгийг  
би авав. Язгуурын эр лүгээ явбаас хамт явсугай хэмээн, үх-  
вээс хамт үхсүгэй хэмээн ам авсан аж. Тиймийн тул энэ ца-  
гийг мэдэгч үзэгч гагц Хоншим бодьсадва буюу. Түүний  
сүмд одож, намагчлаад ам алдсанаа тайлъя гэнэм. бас эх

юүгээн тулд гашуудсан нулимсаа арилгаагүй, бэлбэсэрсэн хувцсаа тайлаагүй, бэлнээр хатан нэрийг яхин авах буй. Бурхан тэнгэрийг мөргөн тахиад, чиний зарлигаар болсугай хэмээсэн буюу. Танху ноён тэр үгийг сонсоод баясаж, зуун багир<sup>12</sup> алт барьж өгүүдрүүн: Энэ зуун багир алтыг авч одоод, юу хэрэглэвээс түүнийг авч өгтүгэй. Өвгөн мөргөж аваад ийн өгүүдрүүн: Гадаад хүрээний хаалга яхин гарах буй хэмээсэнд Танху ноён нэгэн цаазны зэв өгөв. Өвгөн баясаж аваад зэвээ сугандаа хавчуулж, удалгүй гэртээ хүрэв. Хүрээд сац Нарныгэрэлийг нэрлэж дуудаад авай явъя хэмээн өгүүлсэнд Нарныгэрэл өгүүдрүүн: Гадаад их хаалгыг гарч болох буюу. Өвгөн өгүүдрүүн: Авай чи бүү зов, би мэдэх буй хэмээн гурвуул яваад хаалганд хүрвэй. Хаалгач нар үзээд зандарч асууруун: Өвгөн чи энэ хоёр эмийг дагуулж, хааш одох хэмээн асуусанд, өвгөн зэвээ үзүүлээд Нарныгэрэлийн явдлыг худал үгээр дэлгэрэнгүйгээ өгүүлбэй. Төдий хаалгач нар итгэж тэр өвгөн гурвуулыг гаргав. Тэр өвгөн хойш ирээд өгүүдрүүн: Би мартжээ, Танху ноён надад зарлиг болсон билээ. Танай хаалганы гэрийн тоосыг арчиж бай хэмээсэн билээ. Танху ноён энэ хаалганд ирж, манийг хүлээж суух буй хэмээн худал үгсийг өгүүлэн явбай.

Гурвуул тэр үхлийн хаалганаас гараад:

Гурван эрдэнэд наманчлан мөргөөд

Хоншимбодсан хэмээн нэрлэн, дуудан, уншин явбай

Хорт Танху ноён наран унатал эс ирснийг ухаж, төдэй уулын зав заванд эрж эс олбай. Танхуй ноён чандмань эрдэнэ олоод далайд алдсанд адил болов.

Нарныгэрэл хулгайчийн гараас

Гарч явсан хоёрдугаар зүйл

\* \* \*

Бас хүү Үнэнийг өгүүлэгч ноён болсоор таван жил болов. Эх, эм юүгээ санаж уйлаад бичгийн гэрт орж суувай. Хойд гэргий нь Тоонолжингоо ирж асууруун:

Гэрийн эзэн минь ээ

Хэтэрхий их ноён болоод

Хэдэн эд уурс ба ард боол хийгээд

Гэргий чинь би энэ байнам юуны тул царайгаа

барайж суунам аж.

Үнэнийг өгүүлэгч хариу өгүүллүүн:

Би ирэхдээ хөгшин эх ба  
Багаас алсан гэргий юүгээ талбиж энд ирлээ.  
Би тэднийг санаж уйлсан буюу хэмээв.

Тоонолжингоо өгүүллүүн:

Хайран эх эмээ гээх чинь юун буй  
Хайрт эцэг эхийн авч өгсөн гэргийг  
Харанхуй замд гээх чинь юун буй  
Харин эцэгт минь сонсголгүй  
Хар Ланцагийг доогуур зарж илгээе.  
Хадам эх, эгч хоёрыг анраад  
Хамтаар жаргах буй за хэмээн  
Хар Ланцагийг ирүүлээд захисан нь:  
Энэ миний бичгийг авч эцээд  
Нинчан нэрт балгасанд хүрч

Эх эгч хоёрыг минь авчир. Бас зуун багир алт эх эгч хоёрт минь хүнслэн эч. Зуур хулгай, худал олон гэлээ. Сайн морь унаад, саадаг бүсэлж явтугай. Тийн захиж явуулав. Хар Ланцаг хатны зарлигаар морь унаад, саадаг бүсэлж гартал, Лүгү ноён хааны яамнаас иртэл, цав хар Ланцаг хоёр учирвай. Лүгү ноён асууруун: Ланцаг чи саадаг бүсэлж, аль хол газарт одох буюу гэв. Ланцаг аюуж юу ба өгүүлэн ядан сэм байв. Ланцагийг ийн чичирч байхад ханцуйн дотроос бичиг нь унавай. Унасан бичгийг Лүгү аваад үзвээс ийн сэтгэрүүн. Ер үрд итгэж үл болох буюу, зүрхэн мэт эцэг эхэд сонсгохгүй ер доогуур арга үүсгэж зарц илгээх байнам хэмээгээд Ланцагийг лоо нүхэнд орхив.

Үнэнийг өгүүлэгчид, бүү сонсо, би мэдсүгэй хэмээгээд хүргэн охины гэрт ирэхэд хүргэн охин нь угтаж гараад, гэрт залж оруулбай. Лүгү ноён царайгаа барайж өгүүллүүн:

Ай хүргэн охин минь ээ  
Ачит эх гэргий хоёрыг  
Ацрах, асрах явдлын дээд буюу

над үл мэдүүлэх юу буй, дээд эхийг чинь ацрах ёсон хэмээн тамга бичиг зуун алтан багир илгээв.

Дээд эх чинь зуур бүү зовог гэж  
Түүтгэрэл үгүй Ланцагийг сургаж явуулав, би

Хүргэн охин тэд худал үгийг итгэж суув.

Тэндээс бас Нарныгэрэл өвгөн эмгэн гурвуул өдөр шөнөгүй явж, хааны хотод хүрч оров. Нэг хоноод гэр эрж, орох цагт тэр гэрийн эзэн эмгэн угтаж асууруун:

Авай чи аль газрын хүмүүн буй  
Ахуй гэртээ суухгүй  
Асар биеэ зовж  
Аль үйл хэргийн тул энд ирсэн буюу

Нарныгэрэл хариу өгүүллүүн: Нантай мөрний эхэнд Нинчан нэрт балгасанд суусан хүмүүний гэргий буюу. Гэрийн эзэн минь хааны хотод ноён синнэх гэж ирсээр таван жил болов. Миний нэр Нарныгэрэл буюу. Эрийн минь нэр Үнэнийг өгүүлэгч буюу. Эх минь үхэв. Эр минь ирсээр сураггүй. Би гагцаар явж үл болохын тул уул хавцгай гэтэлж ирсэн минь энэ бөлгөө. Тэр гэрийн эзэн эмгэн өгүүллүүн:

Хөгшин хүн би нүдэн бүргийн тул  
Гүн их ноёны хатныг эндүүррөв  
Хүнд зовлонг авай минь  
Хөгшин хүнийг өршөөн соёрх.

Нарныгэрэл хариу өгүүллүүн: Зовж явах эм хүмүүн буюу би. Хэт тийм хатагч хэмээн өгүүлэх юун. Тийм аюух мэт үг бүү өгүүлэгчүн. Гэрийн эзэн эмгэн бас өгүүллүүн. Авай чи эдүгээ миний гэрт суу, Үнэнийг өгүүлэгч ноёны гэрт би одож, чиний ирснийг сонсоё. Нарныгэрэл өгүүллүүн:

Эмгэн чи одож  
Эрийн минь занг болгоо.

Эм гэж хэрэглэх бөгөөс чи урьд ирж, надад өгүүл, үл хэрэглэх бөгөөс би бус газар одож амиа тэжээсү хэмээвэй. Тэр эмгэн хурднаа одоод төдөлгүй Лүгүгийн хаалганд хүрвэй. Тус үгүй, Нарныгэрэл зовох цаг ирсний тул түйтгэр болж Үнэнийг өгүүлэгчид эс золгов. Гэнэт Лүгү ноён учирч эмгэнээс асууруун: Ай эмгэн чи миний яаманд юун хэрэгтэй ирэв. Эмгэн Нарныгэрэлийн ирсэн шалтгааныг дэлгэрэнгүйгээ өгүүлбэй. Лүгү ноён өгүүллүүн: Хүргэн минь бус газар зарга шүүх гэж одлоо, хөгшин хүн би угтаж болох ёсон үгүй, хэдэн гэрийн охидыг илгээе гэв. Еслон залж ирүүлсүгэй! хэмээгээд таван охиныг илгээв. Илгээсэн таван охид ямагт Нарныгэрэлд мөргөвэй. Нарныгэрэл биеэ засч суугаад, тэр

таван охидыг мөргөсөнд юм эс өгүүлсэнд тэр таван охид ийн сэтгэрүүн: Энэ нь гуйланч эм болоод маш их сэтгэлтэй юу буй.

Магад бид тавуулыг мөргөтөл  
Манийг дээш суу гэж үл хэлэхийг юу буй  
Их сэтгэлт энэ эмийг авч одоод  
Их Лүгү ноён лугаа зөвшөөж  
Ерийн нэг арга үүсгэж албаас зохьюу

Энэ муу хаанаас гарах хэмээв. Төдий Нарныгэрэлийг авч одоод Лүгү ноёны хаалгад ороход Лүгү угтаж гараад өгүүллүүн:

Бэрх үнэт бие чинь  
Барашгүй зовлонгоор зовов  
Бас дээд эх чинь үхсэн учрыг  
Балай газрын холын тул  
Бид сонссонгүй.  
Алжаасан бие чинь амух хэрэг  
Алимад манай охин хурим бэлдэж байнам  
Авай урагш орж суугтун  
Насан болсон би дагаж одсугай.

Нарныгэрэл бэрийн ёсоор ёсолж өгүүллүүн:

Эр минь энд ирсний хойно  
Эх минь өвчнөөр үхэв  
Халагт миний бие  
Гагцаар үлдэв.

Эм хүн гагц бие явж үл болохын тул тийм хол газраас эр юүгээн царайг үзнэм болбуу гэж ирлээ. Тийн Лүгүгийн их хаалгад орбай. Дээд их ноён хайрлах бөгөөс чиний охины зарц больё. Лүгү ноён инээгээд өгүүллүүн:

Хайран сайхан биеэ  
Харин муу үгсээр өгүүлэх чинь юун.  
Гайхамшигт чин зоригт энэ биеийг чинь  
Хамаг газрын дээр эс үзвэй би

хэмээн хууран өгүүлэв. Тоонолжингоо ирж өгүүллүүн: Тоосны дунд зовж явсан хүнийг түргэн амруулж суулгах хэрэг хэмээн, Тоонолжингоо Нарныгэрэлийн гараас хөтөлж, өөрийн гэртээ авч оров.

Өөрийн ёсоор ёсолсны хойно Нарныгэрэлийг дээр суулгаж, хүндлэн тавиггаар тахивай. Төдий Нарныгэрэл өөрийн биеийн зовсон шалтгааныг үнэнээр дэлгэрэнгүйгээ өгүүлбэй. Тоонолжингоо сонсоод үнэн сүсэг сэтгэлээр хүндэлж тахивай. Лүгү ноён тэр үгсийг сонсоод ийн сэтгэрүүн:

Энэ эмийн аашлах загнахыг үзвээс  
Эрдэм ихтэй болов уу  
Үүний амь аварваас  
Охин минь зовох хэмээн санан суутал нэгэн ард охин

ирж өгүүллүүн:

Энэ эмийн ааль шинжилвээс  
Эрдэмт ёст буюу  
Үүний амьдарбаас  
Охин бид зовох болмуй за

хэмээн өгүүлсэнд Лүгү ноён өгүүллүүн:

Хэр арга үүсгэж алмуй.  
Гэрийн эзэн Үнэнийг өгүүлэгч эс мэдвээс  
Хэнд биднийг сайн буюу хэмээгээд суув.

Охин бас өгүүллүүн:

Энэ өдөр хуримд  
Эрдэнэ бумбанд архи хийж  
Эрлэг хаанд хүргэх хор хольж өгье  
Энэ эмийн хүүрийг булж орхиё

Үнэнийг өгүүлэгч хаанаас мэдмү. Эрүүт Лүгү ноён тэр үгийг сонсож баясаад өгүүллүүн: Энэ үйлийг та бүгдээр хичээ хэмээсэнд тэр өдөр хурим бэлдэж эрдэнэт бумбанд архи хийгээд, сайн архи өөрийн охиндоо хийж, хорт архийг Нарныгэрэлд өгөв. Үл мэдэхийн тул Нарныгэрэл тэр архийг уугаад, өр өвчит болж, улам хойд архийг уухын урьд удалгүй амнаас хөөс гараад, нүдээ цайлзаж, өгүүллүүн:

Хутагт их нигүүлсэгч Хоншим бодьсан аа  
Хотол амьтныг аварч нигүүлсэгч  
Хувьт энэ бие минь  
Хойд заяандаа сухаавадийн оронд хүрэх болтугай  
Тоонолжингоо чиний эрийг булааж авъя гэж ирсэнгүй  
Тоолш үгүй хор өгөх чинь юун



хэмээгээд хохирон үхэв. Тоонолжингоо мэдээд эцэгтээ уур-  
лаж өгүүллрүүн:

Хайран дээд ахайд минь  
Хар сэтгэлээр хор өгөв үү  
Харин эндүүрч ийм болов уу  
Хайран тунамал наран мэт Нарныгэрэл  
Хар хор идэж үхэв үү чи минь хэмээгээд

өөрийн дээлээ тайлж, Нарныгэрэлд өмсгөж, энэлэн шаналан  
уйлаад ташуур барьж окидоо занчиж асууруун: Охид аюугаад  
илт өгүүлбэй. Манай ноёны зарлигаар алсан буюу. Бидний  
арга бус буй за. Тоонолжингоо тэр үгийг сонсоод эцэгтээ  
ихэд уурлаж, өөрийн гэртээ орбай. Лүгү төдий Нарныгэрэ-  
лийн ясыг аваачиж, хойд хүрээний ёроолгүй худагт орхивой.  
Чулуугаар амсар нь таглаад, чулуун дээр шороо тавьж шо-  
роон дээр бадам цэцэг таривай.

Хорт Лүгү Нарныгэрэлийг адсан гуравдугаар зүйл:

\* \* \*

Тэндээс Нарныгэрэлийн сүнсийг төдий хоёр чөтгөр ирж,  
авч яван атал хутагт их нигүүлсэгч Хоншим бодьсан өөд бо-  
лон ирж, зарлиг болруун: Асар Исэр хоёр чөтгөр та сонс.  
Энэ Нарныгэрэл гагц үзүүрт сэтгэл барьсны тул үүний сүн-  
сийг эрлэг хаанд хүргэж, заяаны толь бичигт үзтүгэй. Үүнийг  
би амьд ертөнцөд эдгэх адистад өгөх буюу хэмээсэнд хоёр  
чөтгөр Нарныгэрэл гурвуул хоёр алгаа хамтатгаж мөргөж  
өгүүллрүүн: Хутагт их нигүүлсэгчийн зарлигаар болтугай хэ-  
мээгээд хоёр чөтгөр Нарныгэрэлийг хөтөлж, авч явав. Та-  
мын ертөнцийн хаалганд хүрвэй. Нарныгэрэл үзээд асуув.  
Энэ ямар хаалга буюу хэний хаалга буюу. Чөтгөр өгүүллрүүн:  
Тамын хаалга хэмээв. Тэр хаалганд дүрвэл үгүй (сааталгүй)  
орж яван атал олон зэс нохой байхыг үзвэй. Нүд нь гилбэл-  
гээн мэт, толгой нь мангасын толгой мэт, соёо нь төмөр гох  
мэт, сүүл нь төмөр могой мэт байвай. Чөтгөр өгүүллрүүн:

Сайн буянт хүнийг  
Сааталгүй гаргах буюу  
Саармаг сэтгэлт хүнийг  
Саатал үгүй залгих буюу хэмээв.

Нарныгэрэл аюул үгүй тэр нохойноос гарав. Бас тийн

яван атал нэгэн өндөр хотон үзэгдвэй. Нарныгэрэл үзээд  
асууруун, чөтгөр өгүүллрүүн: Заяаны урьд үхсэн хүний сүн-  
сийг үүнд хоримуй, усанд үхсэн, ба худагт үхсэн ба, ирт мө-  
сэнд үхсэн ба, боож үхсэн ба, хор идэж үхсэн ба, мориноос  
унаж үхсэн ба, цаг бусын үхлээр үхсэн хийгээдийг үүнд хо-  
рих буюу хэмээсэнд Нарныгэрэл нулимсаа асгаруулж өгүүл-  
рүүн: Би Лүгүгийн хор идэж үхсэн буй, үүнд би бас хориг-  
дох буюу хэмээсэнд чөтгөр өгүүллрүүн: Авай чиний чин зор-  
иг үнэн болвоос үүнд үл байх буюу хэмээв. Тийн яван атал  
цусаар урсах нэгэн мөрөн үзэгдвэй. Нарныгэрэл бас асуу-  
руун, чөтгөр өгүүллрүүн: Амьд ертөнцөд эм хүн хөвүүн тө-  
рөхдөө бурханы суух оронд цусаа дусаасан ба бурхан номын  
дэргэд буртагт хувцсаа талбисан ба, буртагт эдээ урсах усанд  
угаасан эмийг үүнд эрүүлэх хэмээв. Тийн яван атал Манхи  
нэрт балгасанд хүрвэй. Тэр балгасанд Ман нэрт эмгэн аж-  
гуу. Тэр эмгэн их дуугаар: Та өлссөн ундаассан бөгөөс цай  
уугтун хэмээн дуудвай. Чөтгөр өгүүллрүүн: Нэгээхэн бээр  
гэм үгүй энэ Нарныгэрэл буюу, балай их дуугаар дуудах  
юу вэ. Нарныгэрэл өгүүллрүүн: Тэр асрах сэтгэлт эмгэний  
өгөх цайг та юунд хорином. Та хоёул өчүүхэн түдэн соёрх  
Тамшаах ам минь хатав. Тэр цайг өчүүхэн ууя би. Чөтгөр  
өгүүллрүүн:

Алимад энэ цайг уусны хойно  
Амьд ертөнцөд харихуйяа бэрх болмуй  
Ахуй бүгдээрийг мартаж хор буй  
Авай чи цай бүү хүсэгтүн хэмээгээд тийн яван атал

нэгэн мөсөн уул үзэгдвэй.

Салхин нь хүйтэн болоод  
Сац олон хүнийг нүцгэлж  
Салхит ууланд суулгавай

Сэрүүцэж хүйтэн нь их болоод үл тэсэн уйлахуй, гасла-  
хуйд Нарныгэрэл үзээд асуув. Чөтгөр өгүүллрүүн: Амьд ер-  
төнцөд

Баян ноён хүмүүн бөлгөө  
Балай олон амьтны амь тасалсан ба  
Багш ламыг доромжилсон ба  
Балмад худал сэтгэлээр хаан төрийг чив болгосон ба  
бэрх үнэт эдээ бузарласан хийгээдийг үүнд ирүүлмү хэмээв.

Тийн яван атал баганат там үзэгдэв. Тэр баганад олон хүнийг хүлээд, хэлийг огтолж сац цусыг нохой долоож байхыг үзээд Нарныгэрэл асуув. Чөтгөр өгүүллүүн: Амьд ертөнцөд

Хуурамч худал хулгай ба  
Хонтож бусдын сайн эдийг авсан ба  
Ховолж хүнийг хагацуулсан ба  
Хуврагуудыг үлдсэн хийгээдийг

үүнд ирүүлмү хэмээв. Тийн яван атал бас гал ширээт там үзэгдвэй. Нарныгэрэл асууруун, чөтгөр өгүүллүүн:

Эцэг эхийг алсан ба  
Эр юүгээ ховолсон ба  
Эхдээ хурьцсан ба

арван зүгийн бурсан хуврагуудын эдийг хулуусан хийгээдийг үүнд ирүүлмү хэмээгээд зорчвой. Тийн яван атал бас нэгэн тай үзэгдвэй. Тай дээрээс харж үзвээс амьд ертөнц үзэгдвэй. Ном буян үйлдэх ба бэлбэсрэх ба гашуудах ба хэншүү шатаах ба, цаас түлэх хийгээдийг үзээд Нарныгэрэл нулимсаа асгаруулж өгүүллүүн:

Ай эр минь баян сайн болоод  
Эд таваарт шунахайрч

Эх, эмийн тулд өчүүхнээр ном буян эс үйлдэв, сая хэмээгээд тайгаас бууж яван атал арван найман там хийгээдийг цөм үзэж саатал үгүй гарсаар эрлэг номын хааны хаалганд хүрвэй. Долоон эрдэнээр бүтсэн хаалгат буюу. Хаалгын дээр алтан шин лүн чин хэмээн бичиж байв. Тэр хаалганд дүрвэл үгүй ороод, эрлэг номын хаанд золгов. Есөн үе мөргөж, гурван үе сөгдсөний хойно эрлэг хаан асууруун: Аль газрын эм буй, аль хэрэгт их хаалганд оров хэмээн зарлиг болсонд Нарныгэрэл өгүүллүүн:

Нантай мөрний эхэнд  
Нинчан бадгасанд төрсөн хүн билээ  
Эрийн минь нэр Үнэнийг өгүүлэгч буюу

Миний нэр Нарныгэрэл буюу. Амьд ертөнцөд эх юүгээн тэжээснийг, Танху хулгайчид баригдсаныг, Лүгү ноён хор өгч алсан шалтгааныг дэлгэрэнгүйеэ айлтгавай. Ер бус хоёр заяандаа зүйл зүйлийн зовлон үзвэй. Заргыг минь хагалах хүн үгүйн тул их хаан чамд би ирлээ. Эрлэг хаан тэр

үгийг сонсоод заяаны бичгүүдийг нээж үзээд зарлиг болруун: Нарныгэрэл хорин нэг наслахын хоорон дунд гурван их зовлон үзэх заяат буй гэв.

Алжаас үгүй махаа хадам эхдээ огтолж идүүлэх  
нэгэн зовлон

Уулын Танху хулгайчид баригдсан хоёр зовлон  
Аргат Лүгү ноёны хор идэж үхэх гурван их зовлон.

Түүнээс бус наян нэг наслах заяат хэмээв. Хоёр чөтгөр та энэ Нарныгэрэлийн сүнснийг амьд ертөнцөд хүргэ. Амьдрах адистадыг их нигүүлсэгч Хоншим бодисан өгөх буюу хэмээн зарлиг болов. Нарныгэрэл алгаа хамтатгаж өгүүллүүн:

Ихэд асрахуйт номын хаан минь  
Ер намайг нигүүлсэх үнэн бөгөөс  
Зовлонгоор дарагдсан эх минь энд бөлгөө  
Золгож болох болов уу номын хаан минь ээ.

Эрлэг хаан зарлиг болруун:

Гайхамшигт энэ Нарныгэрэлийг  
Харанхуй тамд одоод  
Хадам эхдээ золгож ирээд  
Харин амьд ертөнцөд одном хэмээн зарлиг болов.

Төдүй хоёр чөтгөр ирж эхэд нь хүргэвэй. Эхийг хүзүүнд төмөр дээсээр гинжилж, морь үхэр тэргүүт чөтгөр хадгалсан аж. Чин сэтгэлт Нарныгэрэл ороод, цав, эх, бэр хоёул тэврэлдэн уйлахад чуулсан олон чөтгөр бүгдээр цөм өр элгээ унасан мэт байв. Нарныгэрэл нулимсаа асгаруулж өгүүллүүн: Танху хулгайчид баригдсаныг, Лүгүгийн хор идэж үхсэнийг, эрлэг хаанд заалдсаныг, амьд ертөнцөд харих шалтгааныг дэлгэрэнгүйеэ өгүүлбэй. Эх нь өгүүллүүн:

Зүүд мэт ертөнцөөс хагацсаар  
Зүйл зүйлийн зовлон үзвэй, би  
Зовж хөвүүн төрөөд  
Зүдэж гурван жил болтол  
Сүүгээ хөхүүлвэй, би  
Элдэвчлэн тэжээж их болгоод  
Эд таваар хайрлалгүй өгч,  
Эрдэм билгийг сургавай  
Эрил үгүй ноён болж бүрүүн

Миний ачийг мартав.

Би энэ тамаас хэзээ гарму

Бэр минь чи харьсан хойно

Багш лам нарыг хурааж

Батад тонилохуй номуудыг үйлдвээс

Барш үгүй энэ тамаас гарнам болов уу, авай минь.

Хайран хөвүүн чамаас хагацсаар

Харанхуй тамд хэвтнэм хэмээн өгүүл, авай минь

Хайрлан тэжээсэн ачийг санаваас

Харанхуй энэ тамаас тонилгон соёрх, авай минь, чи

хэмээгээд уйлахад хоёр чөтгөр ирээд амьд ертөнцөд авч одвой. Одсод сац Жин улсын хааны хотод хүрвэй. Чөтгөр өгүүллүүн. Яс чинь худгийн ёроолд байнам гаргаж авбаас эдгэмү, эс гаргаваас яахин эдгэмү. Урьд эрдээ зүүд өг, ясыг чинь гаргасны хойно эдгэмүй за хэмээсэнд Нарныгэрэл Лүгүгийн хаалганд орох цагт хаалганы сахиулсан эс оруулав. Чөтгөр өгүүллүүн: Лүгүгийн өчүүхэн сахиулсан чи сонс. Бид дээд хутагт их нигүүлсэгч Хоншим бодисаны адистаар эрлэг номын хааны зарлигаар энэ Нарныгэрэлийг амьд ертөнцөд хүргэж ирсэн бөглөө. Хаалганы сахиулсан тэр үгийг сонсоод өгүүллүүн: Тийм бөгөөс үтэрхэн ороод хурдан ир. Төдүй Нарныгэрэл ороод зүүд өгье гэтэл Үнэнийг өгүүлэгч амьд бүхийн тул тэргүүндээ гал бадрахыг үзээд, Нарныгэрэл аюуж гартал чөтгөр орж тэр галыг сөнөөвэй. Нарныгэрэл эр юүгээн дэргэд хүрч зүүд өгөв. Эх юүгээн махаар тэжээсэн, эх юүгээн үхсэн, Танху хулгайчид баригдсан, Лүгүгийн хор идэж үхсэн, эрлэг хаанд заалдаж амьд ертөнцөд харьж ирсэн шалтгааныг дэлгэрэнгүйеэ өгүүлбэй. Тийн уйлахад төдүй хоёр чөтгөр ирж өгүүллүүн: Тахиа дуугарах цаг болов. Үтэр явъя хэмээгээд авч харив. Нарныгэрэл Эрлэг хаанд заалдаж амьд ертөнцөд харьж ирсэн дөтгөөр зүйл.

\* \* \*

Тэндээс Үнэнийг өгүүлэгч сэрээд тэр Нарныгэрэлийн зүүд өгсөн үгсийг түгдрэлгүй санаад дааш үгүй зовлонт болов.

Эх, эм юүгээ үхсэнийг ухаж ийн сэтгэрүүн

Энэ Лүгү ноён маш их хааны эрхэт буюу

Үүнийг би чадах бус бурхан тэнгэр зөв бурууг  
ялгах байнам

хэмээгээд суув. Тэндээс Нарныгэрэл хүүрээ авч үл чадан, дүүлэн хөрвөн гаслан явахад дээд их нигүүлсэгч Хоншим бодисан ухаж тэнгэр нарын эрхэм хурмаст тэнгэрийг ирүүлж зарлиг болруун: Тэнгэр нарын эрхэт ээ! Хөөрхий энэ Нарныгэрэлийн чин сэтгэл нь гагц үзүүрт буюу. Тиймийн тул би нигүүлсмү, үүнийг. Лүгүгийн хойд хүрээнд чин сэтгэлт Нарныгэрэлийн хүүр чулуугаар тагласныг эвдэж аваад ирж, надад өгтүгэй чанд эрхэт тэнгэр минь.

Хурмаст тэнгэр алгаа хамтатгаж өгүүллүүн

Хутагт их нигүүлсэгч

Хувьт амьтныг тонилгох сайн үйлсэд

Хурднаа би эчсүгэй, хэмээгээд

Тэнгэр нарыг хурааж ийн захирвай

Гэмт Лүгүгийн хойд хүрээнд

Гийсэн Нарныгэрэл нэрт дагины ясыг

Хий тэнгэр, гилбэлгээний тэнгэр

тэргүүлэн үтэр одож

Тэр ясыг авч ирээд

Дээд хоншим бодисадваад өргөтүгэй.

Тэнгэрс та бүгдээр хэмээн тийн захирсанд

Хамаг тэнгэр нар төдий догшин хур оруулаад

Хар аянгыг буулгаж, газар хагалаад

Гайхамшигт Нарныгэрэлийн ясыг авч Хоншим бодисаны дэргэд хүргэвэй. Хүргээд сац

Амьдрах мандалыг үүсгэж

Ариун сэтгэлт

Нарныгэрэлийн хүүр

Найман эрхтэн бүрдэх

Авшиг талбиад сац

Амин нь орж

Махбод нь бүтвэй

Төдүй Нарныгэрэл унтаж сэрсэнд адил нүдээ нээж үзээд, яаран босч алгаа хамтатгаж, мөргөн өгүүллүүн:

Хутагт их нигүүлсэгч

Хоншим бодисан минь

Хувьт амьтныг тонилгохын тул

Хурднаа энэ миний бие эдгээсэн адистаар

Хойд заяанд чиний тойнд орсугай би.

Тэр Нарныгэрэл хоншим бодисадын адистаар

Эр баатар зүрхэт болж дайсныг дарах хүчин аугаа  
ба тэр барих билиг ба хариу өгүүлэх мэргэн бурханы номуудыг  
сүсэглэсэн ба хамаг амьтныг асрахуй хийгээдийг цөм биедээ  
оршуулвай. Хоншим бодисан төдий Нарныгэрэлийн биеийг хүний  
ертөнцөд буулгаж талбибай. Нарныгэрэлийн амьдрах адистид  
олсон, хүний ертөнцөд буулгаж явсан тавдугаар зүйл.

\* \* \*

Тэр цагт Танху нэрт хулгайч түг түмэн цэргүүдийг хурааж  
мордоод тэр Жин улсын хааны цэргийг дарвай. Төдий Жин улсын  
хаан аюугаад дайсныг дарах баатар хүнийг эрж, тэр улсад тунхаг  
тархавай. Тийн хэмээхийг Нарныгэрэл сонсоод төдий цэргийн  
ноёнд одсонд тэр цэргийн ноён асууруун:

Ай чи аль газрын эм буй  
Аль эрдмээр дайсныг дарах гэнэм  
Авай чамаас болох нь  
Эуун мянган баатрууд  
Ашид ор үгүй цөм автвай  
Хамаг дайсанд алалдах цагт чи эм хүмүүн буюу  
Ааль чинь хөтөлмуй за  
Ая хайран залуу амиа мэдэгтүн.

Нарныгэрэл өгүүллүүн:

Би эм хүн үнэн буюу  
Би баатар хүчин аугаат  
Би риди хувилгаат  
Би тэр муу Танху хулгайчаас аюух бөгөөс  
Бие минь урьд засгаар явуул.  
Магад би дайсныг дараг чадваас  
Магад их төрийг тогтсон чадваас  
Магад чинийх бус хэнийх буй.

Цэргийн ноён тэр үгийг нь сонсож ийн өгүүллүүн: Тийм бөгөөс  
эрдмийг чинь үзсү хэмээн нэгэн дааш үгүй нум өгвөөс төдий  
Нарныгэрэл тэр нум сумыг аваад есөн үе харвааас нэгэн бээр  
эс алдав. Басхүү бүх хүчин, арга билиг тэргүүтэн эрдмүүдийг  
барш үгүй тэр цэргийн ноёнд үзүүлвэй. Цэргийн ноён гайхаж  
баясаад төдий Нарныгэрэлийг тэр цэргийн тэр-

гүүн ноён болгож, арван түм илүү тоот цэргийг авч, Танху хулгайчид мордов. Ялж хулгайчийн ууланд хүрвэй. Тэр Танхугийн нөхөд нь үзэж яаран Танхуд өгүүллүүн: Ай их Танху ноён сонс, манай уулан доор тоо томшгүй цэргүүд ирж байнам. Нэгэн охин баатар цэрэг тэргүүлж явнам. Бас нэг ноён цэргийг эзэлж явнам.

Илд жад нь ойд ургасан бургас мэт  
Илт туг хиур нь үзвээс нүдэнд гилбилгээн мэт  
Ялангуяа цог сүлд нь маш аюух мэт  
Түүнийг хариулах аргыг их ноён мэдтүгэй гэв.

Танху тэр үгсийг сонсоод инээж өгүүллүүн:

Ер та бүгдээр сонс  
Ер эртнээс янагш  
Эр баатар цэрэг тэргүүлж яван бөлгөө  
Зүү утас барих эм хүнээр  
Цэрэг тэргүүлж явах ёсон үгүй бөлгөө

Жин улсын цэрэг хэмжээ ойр болсны тул эм хүнийг илгээсэн буй за хэмээгээд уулнаас бууж, хоёр цэрэг байлдахаар завдсанд Танху ноён цэргээс гараад дуудаж өгүүллүүн: Жин улсын хааны ямар баатар ирж, Танху их ноён лугаа яахин золголдном хэмээсэнд мөнхүү Нарныгэрэл бас цэргийн өмнө гарч өгүүллүүн: Миний бие Жин улсын хааны омогт охин баатар буюу. Миний нэр Нарныгэрэл буюу. Муу хулгайч лугаа золголдох би бөлгөө хэмээсэнд, Танху инээгээд өгүүллүүн: Миний амраг эм буюу чи. Хорт өвгөн, эмгэн чамайг авч боссон хойно эрж эс олбай. Эдүгээ чам лугаа учирсан нь тэнгэр эцэг намайг хайрласан буй за. Амраг эм минь янагш ир. Жин улсын хааны цэргийг дараад бид хоёр хаан хатан хэмээн цол дуудаж, хамтаар жаргалдъя хэмээсэнд Нарныгэрэл уурлаж өгүүллүүн: Би Жин улсын хааны омогт охин баатар буй. Муу хулгайч үхэх юүгээ унтахын төдий үл санах байнам.

Бишрэлт адистид аугаа хүчит би буюу  
Бэрд мэт Танху чамайг товрог болгоё хэмээн ирлээ  
би хэмээсэнд Танху инээгээд өгүүллүүн:

Цэргийг даран чадах би  
Чулууг хийсгэн чадах би  
Чөтгөрийг номхотгон чадах би

Чамайг авч эм хийн бөлгөө.  
Нарныгэрэл уурлаж билгийн илдээ бариад ороход Танху  
бас уурлаж жад бариад оров. Хоёулаа золголдвой.  
Гурван үе зорчиж эс дийлэлцвэй.

Гучин үе зорчсон хойно  
Хулгайч нэгэнт уурлаад  
Хурьцал үгүй тарни уншиж  
Хоромхон зуур чулуу хадыг хийсгэхэд  
Хувьт Нарныгэрэл  
Хоёр алгаа хамтатгаж  
Хоншим бодьсан хэмээн нэрлэн уншваас  
Хоншим бодьсан хурмаст тэнгэр хоёр ирж  
Танхугийн хийсгэсэн чулууг дараад  
Тэрсүүдийн тарни доройтсонд  
Тэр хийссэн чулуу  
Хадыг мөн эзэнд тусгасанд  
Хамаг хулгайчийн цэргүүд дутаав  
Хар мөр Танху басхүү дутаав  
Харил үгүй Нарныгэрэл  
Хариугүй хөөж гүйцээд  
Харцгай шувуу туулай барьсан мэт болговой.

Танхуг амьд бариад сац цэргийн их ноён хүргэж өгвэй.  
Цэргийн ноён маш баясаад ийн хэмээн магтвай.

Чин зоригт баатар дагина чи  
Сүүн далай мэт дагина чи  
Чивэлт шулмасын цэргийг доройтуулагч дагина чи  
Жин улсын хаанд эрхэт болох болтугай

хэмээгээд цэргүүдийг хурааж, хааны хотын зүг цэнгэлдэн  
явбай. Өдөр шөнөгүй дүлэн явж хааны хотод хүрвэй. Тэр  
цэргийн ноён урьд хаанд Нарныгэрэлийг золгосон, Танхуг  
барьсан шалтгааныг дэлгэрэнгүйе айлтгав.

Хаан тэр үгийг сонсоод  
Ханал үгүй баясаж  
Зарлиг болруун:  
Гайхамшигт тэр охин баатар Нарныгэрэлийг  
Хамаг сайд ноёд та угтаж  
Миний орд харшид оруул хэмээн зарлиг болсонд  
Хэдэн тэр баригч ноёд сайд

Гийсэн Нарныгэрэлийг угтаж ирээд  
Хэдэн хаалга нээж Нарныгэрэлийг хааны харшид  
оруулвай

Хаан үзэж баясаад  
Хаш ердөнө сандалд суулгав.  
Хаан бас Нарныгэрэлд  
Аягаа барьж ийн магтруун:  
Дээд баатар дагина чи  
Танху хулгайчийг дараад  
Тэнсэл үгүй луугийн сууринд суугаад  
Тэгш хамгийг амгалан болгосон нь

Тэнгэр эцэг намайг өршөөсөн буй. Тийнхүү чи надад нэгэн хүчтэн болов хэмээгээд Нарныгэрэлийг төрийг баригч дээд ноён болгож эрх өгвэй. Басхүү Танхуг сайтар эцэлгэ. Тэргүүнийг нь хотын эх хаалганд өлгөтүгэй. Надад буруу сэтгэгчид үзтүгэй хэмээн зарлиг болсонд төдний ноёд сайд тэр Танхуг эцэлгээд тэргүүнийг нь хотын хаалганд өлгөвэй. Нарныгэрэл Танхуг бариад Жин улсын хаанд эрх өгтөж ноён болсон зургадугаар зүйл.

\* \* \*

Тэндээс хаан бас зарлиг болруун: Охин баатар Нарныгэрэл минь, төрийг барих хүмүүн чи, эдүгээ ноёд түшмэд тэргүүлэн харцас хүртэл тэнсэж шүүгээд зөвийг өргөтүгэй, бурууг тэвчтүгэй. Хойно нь надад ирж айлтга хэмээн ихэд эрх өгвэй. Нарныгэрэл тэр зарлигийг сонсоод есөн үе мөргөж аваад харивай. Түүний маргааш хааны их хатан хурим бэлдэж, Нарныгэрэлийг уривай. Нарныгэрэл одож, хааны хатанд айлчтал есөн үе мөргөөд, суусны хойно ард охид хурим өргөж талбив. Нарныгэрэл мөргөн идэв. Хатан зарлиг болруун:

Хааны их төрийг баригч охин баатар чи  
Хамаг дайсныг дарах эрдэм суран бөгөөтөл  
Харин нөхөр чинь юунд эс сурсан буй.

Нарныгэрэл:

Эр юүгээ хааны хотод ирсэн,  
Эхдээ махаа огтолж идүүлсэн, эх юүгээ үхсэн,

Танхуд баригдсан, Лүгү ноён хор өгч алсан, эрлэг хаанд заалдаж, амьд ертөнцөд харьж ирсэн, хоншим бодьсан тусалсан, Танхуг барьсан шалтгааныг дэлгэрэнгүйе айлтган харивай.

Хатан тэр үгсийг сонсоод  
Гайхамшигт явдал мөн хэмээн  
Хаанд нарийнаа өчвөөс  
Хаан зарлиг болруун:

Нарныгэрэлд би эрх өгвэй. Лүгү ноён, Үнэнийг өгүүлэгч хоёрыг зөв бурууг шүүж мэд. Засгаар хийтүгэй, тийн болвоос Лүгү гэгч надад гучин жил болтол хүчээ өгсөн эрхэм сайд буюу. Алахуйяа бус, тийн ташуур барьж гэрээс гартугай хэмээн миний зарлигийг Нарныгэрэлд хүргэ гэж элч илгээв. Тэр элч одож, Нарныгэрэлд хааны зарлигийг төгс соёрхой. Нарныгэрэл угтаж мөргөн аваад, хааны зарлигаар болтугай хэмээв. Хааны төрийг Нарныгэрэл гагц бие даахын тул их, бага ноёд түшмэд цөм Нарныгэрэлийн яаманд чуулан байв. Нарныгэрэл ийн сэтгэрүүн: Дотоод гадаад ноёд минь гадаа чуулж бөлгөө. Лүгү ноён, Үнэнийг өгүүлэгч хоёр намайг таних болбуу хэмээн үүдээ буулгаж суув. Төдий дотоод гадаад ноёд цөм Нарныгэрэлд бэлэг барьж мөргөхөд, Нарныгэрэл өгүүллүүн: Миний бие доорд эм хүмүүн бөлгөө. Ямар эрдэм буй хэмээн их бага сайдын бэлгийг яахин дааж аван чадах би хэмээв. Олон ноёд ийн магтруун:

Охин баатар буй чи  
Үлэмж дээд хааны төрийг тогтоон суутал  
Удаан золгосон гэмээн бид биедээ авсугай

хэмээгээд гартал Нарныгэрэл өгүүллүүн: Сайд түшмэд та түргэн суугтун, төрийн үйл хэлэлцье гэв. Төдий ноёд түшмэд баруун зүүн этгээд суув. Нарныгэрэл өгүүллүүн: Ноёд сайд та сонсо. Улс иргэнийг ямар засгаар зохиом. Ноёд нь хариу өгүүллүүн:

Өөрийн даасан үйлийг засгаар гэсгээж  
Үнэн засгийн ёсоор чанд болгож  
Боловсон шударгуу сэтгэлийг бариад  
Буцал үгүй зальхайг тэвчиж явбаас  
Бодтойяа сайдын манлай тэр буюу  
Эзний төрийг осолдож этгээд явбаас  
Эзний засгийн мөрөөр явуулж  
Эрүүлэн үйлдэх хэрэг гэв.

Нарныгэрэл өгүүллүүн: Ноёд сайд та цөм харь, Үнэнийг өгүүлэгч ганцаар суу, олон төрийн үйл хэлэлцье хэмээн олон



ноёд сайдыг тархаавай. Нарныгэрэл Үнэнийг өгүүлэгчид өгүүллүүн:

Чи дотоод яамны их мэдэгч ноён буюу  
Чамд даасан үйлийг  
Чанд ямар сэтгэлээр бариму  
Чин үнэн сэтгэлийг ямар аргаар хадгалму

хэмээн асуусанд, Үнэнийг өгүүлэгч аюун өгүүллүүн: Үлэмж дээдийн төрийг баригч баатар дагина чи сонс, дотоод яамны үйлийг мэдэж, улс иргэн энх амгалан яван бөлгөө хэмээв. Нарныгэрэл өгүүллүүн: Улс иргэнд нэгэн бичээч эрдэмт хүмүүн бөлгөө. Төрсөн эх юүгээ орхиж, багаас учирсан гэргий юүгээ гээж, ноён больё хэмээн хааны хотод ирээд алимад ноён хүний охиныг аваад,

Асар жаргалдаа ташуурч  
Ачит эх юүгээ үхтэл  
Ач тусыг сэтгэж, ном буян хийсэнгүй  
Амраг хойд эмтэйгээ зөвлөлдөж

өчүүхнээс учирсан эм юүгээ алсан хүнийг ямар засгаар засваас зохиму. Үнэнийг өгүүлэгч өгүүллүүн:

Тэр бичээч хүн  
Түүтгэрэл үгүй ном бичиг мэдэх бөгөөтөл  
Төрсөн эх төвлөлдсөн гэргий юүгээ мартаад

хойд гэргий авсан хүн үгүй буй за хэмээв. Нарныгэрэл бас өгүүллүүн: Би сонсохул чамд гурван их ял буй гэнэм. Үнэнийг өгүүлэгч хариу өгүүллүүн: Гэгээн оюут охин баатар чи гурван их ял буй хэмээн өгүүлэхээс хэтэрхийеэ нэгээхэн гэм үгүй бөлгөө хэмээхүйд Нарныгэрэл уурлаж өгүүллүүн:

Эх юүгээ үхтэл ном буян эс үйлдсэн чинь нэгдүгээр  
Эд таваарт орж, өчүүхнээс учирсан гэргий юүгээн  
тэвчсэн хоёрдугаар  
Хойд эмтэйгээ зөвшөөж, урьд авсан эм юүгээ  
алсан чинь гуравдугаар

энэ биед хийсэн гурван их ял чинь тэр буюу.

Эмийн чинь үгийг би сонслоо  
Эх чинь чамайг санасаар  
Өвчин олж үхэв гэнэм  
Өвдөхдөө мах идье гэхэд

Эм чинь мах эрж эс олоод  
Өөрийн махаа огтолж идүүлж гэнэм  
Үүрд үхсэн хойно  
Эм чинь бэлбэсэрэв гэнэм  
Эртний үг:  
Эр хүн эм үгүй бөгөөс  
Гэр хоосон гэлээ  
Эм хүн эр үгүй бөгөөс  
Ганцаар гэлээ.

Тиймийн тул эм чинь бус сэтгэлийг тэвчээд, чамайг гэж эрж ирсээр барсын аманд унав гэнэм. Хар мөрт Танхуд баригдаж хатан хийе гэхэд эм чинь эс болж, ачит өвгөн эмгэн хоёр авч гараад, хааны хотод хүрч ирэв гэнэм. Бас барсын амнаас гарч, нүүр үгүй ирвэсийн аманд унав гэнэм. Хуурамч сэтгэлт Лүгү хор өгч, эмийг чинь алав гэлээ. Үнэнийг өгүүлэгч тэр үгийг нь сонсоод хоёр нүднээсээ нулимс асгаруулж, хариу өгүүллүүн: Миний зоригоор эм авсан бус, муу сэтгэлт Лүгү эрүүлж охиноо өгсөн буй за. Хар Ланцаг нэрт хүнийг илгээж миний эх гэргий хоёрыг авч ир гэж илгээлээ.

Эдүгээ болтол ирсэнгүй  
Эх минь үхсэнийг би сонссонгүй  
Эм минь энд ирж алагдсаныг сонссонгүй  
Энэ бие минь улсын ноён болтол  
Ийм буруу явах ёс буюу

хэмээсэнд Нарныгэрэл уурлаж өгүүллүүн: Муу чиний эм энд буй бөгөөс чи таних, үл таних? хэмээсэнд Үнэнийг өгүүлэгч өгүүллүүн:

Өчүүхнээс авсан сайн гэргий минь бөгөөс  
Үл таних гэгч юун буй хэмээн өгүүлэв.

Нарныгэрэл өөрийн нөхдөдөө өгүүллүүн: Нөхөд та миний үүдийг дээш сөх. Үнэнийг өгүүлэгчийн эмийг үзүүлье хэмээгээд үүдээ сөхөж үзүүлэв. Үнэнийг өгүүлэгч Нарныгэрэлийн царайг үзээд сац тэргүүндээ хүйтэн ус цутгасан мэт биеэ чичрээд өгүүлэн ядан сэм байв. Нарныгэрэл нулимсаа асгаруулж өгүүллүүн:

Энэ цухал сэтгэлт хүн  
Эдүгээ авсан амраг гэргий юүгээ авч явму  
Үл явму, үтэр өгүүл хэмээвээс аргагүйн тул Үнэнийг

өгүүлэгч өгүүллүүн: Алваас чиний зориг, аварваас чиний зориг. Намайг юу өгүүл гэнэм хэмээсэнд гаднаас нэгэн хүн ирээд Нарныгэрэлд өгүүллүүн: Гадны Лүгү ноён ирж байнам хэмээсэнд Лүгү ноёныг оруул хэмээв. Төдий Үнэнийг өгүүлэгчийг хойд гэрт оруулбай. Үүдийг минь буулга хэмээв. Лүгү ноён ийн сэтгэрүүн. Жин улсын хааны их ноён би бөлгөө. Чанаргүй эм хүнд ирж мөргөх байнам хэмээгээд орж Нарныгэрэлд мөргөөд ийн магтруун:

Эдүгээ охин баатар чиний хүчинд  
Эрүүт хулгайчийг шүүрээр шүүрдсэн мэт болгов.

Хамаг иргэнийг амгалан болгов чи хэмээгээд хартал Нарныгэрэл өгүүллүүн:

Дээд тэнгэрийн хөвүүний цог залиар  
Дэд Лүгү ноён чиний арга билгээр  
Тэнсэл үгүй баатруудын хүчинд

Тэнсэл үгүй улс иргэнийг хишигээр хулгайч доройтсан буй эа хэмээгээд Лүгү ноёнд сандал тавьж өг, цай уулга гэв. Лүгү ноён суусны дараа Нарныгэрэл өгүүллүүн: Дээд хааны зарлигаар дотоод яамны их ял гурав байнам. Намайг шүү гэж бөлгөө. Их Лүгү ноён бид хоёул зөвшөөж шүүе гэв. Лүгү ноён харну өгүүллүүн: Тийм болтугай хэмээгээд суув. Нарныгэрэл бас өгүүллүүн:

Гурван сууринд суусан зусар хулгайч  
Хуурамч ноён хүн буй буюу  
Охиноо нэгэн бичээч ноён хүнд өгөөд  
Урьд авсан гэргийг нь хор өгч алаад  
Ясыг нь хойд худагт хийж  
Чулуугаар таглаад түүний дээр лянхуа цэцэг тарив  
гэнэм

Тийм их ялт ноёныг намайг шүү гэж хаан зарлиг болсон бөлгөө. Лүгү өгүүллүүн: Тэр ноён гүн их сууринд суусан, эдүгээ энэ цагийн хүн буюу урьд цагийн хүн буюу. Нарныгэрэл өгүүллүүн: Урьд цагийн хүн бус, эдүгээ нүдний өмнө байх үйл буюу. Лүгү өгүүллүүн: Энэ цагт гүн их гурван сууринд суусан ганц хөгшин хүн би бөлгөө. Харанхуй ийм явдал хаанаас ирэв. Ийм явдал надад үгүй буюу хэмээсэнд Нарныгэрэл уурлаад үүдээ сөхүүлж үзүүлээд зусар хөгшин хулгайч,

миний царайг таньж үз хэмээв. Лүгү харж үзээд биед сүнс нь үгүй болов. Биеэ чичирч өгүүллүүн: Охин баатар чи бүү уурлагтун. Миний бие үүсгэсэн арга бус, гэрийн зардас охидын үүсгэсэн арга буй гэв. Нарныгэрэл өгүүллүүн: Энэ хөгшин хулгайчаас ямар сайн үг сонсох буй. Миний нөхөд та одож Лүгүгийн гэрт эчээд, охин Тоонолжингоо тэргүүлэн зарц охидыг нь цөмийг авч ир хэмээсэнд төдий нөхөд нь хурднаа одоод Тоонолжингоо хамаг зарц охиныг хурааж, Нарныгэрэлийн дэргэд авч ирэв. Нарныгэрэл Тоонолжингоогоос асууруун: Би чиний гэрт ирэхүл чи надад юу гэж хор өгч алав. Тоонолжингоо чи үтэр өгүүл гэв. Тоонолжингоо аюугаад сөгдөж өгүүллүүн: Охин баатар миний гэрт ирсэнд би үнэнээр чамайг хүндэлж, эгч хийе гэж явтал гэрийн охид арга үүсгэж, охин баатар чамайг алсан буй за. Би үнэнээр мэдсэнгүй буюу хэмээсэнд Нарныгэрэл өгүүллүүн: Энэ хөөрхий гэм үгүй үнэн буй. Миний яамны хойд гэрт оруул хэмээн Тоонолжингоог хойд гэрт оруулав. Бас олон хулгана мэт охидоос асууруун: Аргыг хэн үүсгэв. Охид өгүүллүүн: Охин баатар манай гэрт ирсэн учирт бид бүгдээр хүндлэн тахиж бөгөөтөл үхлийн эзэн хэзээ ирэх мэдээ үгүйн тул охин баатар чи өөрөө бурхан болбой. Хор өгч алахыг бид мэдсэнгүй хэмээв. Нарныгэрэл инээгээд өгүүллүүн: Лүгү ноёнд ташуур авчирч өг. Охидоо элдэж асуутугай. Төдий олон охид нь ташуур авчирч Лүгүд өгөв. Лүгүгийн сэтгэрүүн: Энэ охид дам үгүй миний биед түлхэх байнам. Огоот алваас илд бус яасугай хэмээн аргагүй элдэж асуув. Охид өгүүллүүн: Ноён минь чи бид бүгдээр аргыг үүсгэж алсан буй за. Манай биеийг охин баатар элдвээс зохъёюу, чи элдвээс үл зохъюу гэв. Нарныгэрэл тэр үгсийг сонсоод машинд хилэгнэж ийн өгүүллүүн: Энэ хөгшин хулгайчийг эр, эм хоёуланг ташуур хайч бариулж, гэрээс гарга. Энэ хулгана мэт охидыг тэвч хэмээсэнд төдий Лүгү ноён хатан хоёуланг ташуур хайч бариулж гэрээс гаргав. Олон охидыг булт тэвчив. Нарныгэрэл аргат Лүгүг үлдээд, хор өгөгч охидыг тэвчиж, Үнэнийг өгүүлэгч эрдээ золгосон долоодугаар зүйл.

\* \* \*

Тэндээс Нарныгэрэл өөрийн эр юүгээ Үнэнийг өгүүлэгчийг хойд гэрээс гаргаж өгүүллүүн: Ай муу чи биеийн гэмийг мэдэв үү хэмээсэнд Үнэнийг өгүүлэгч хариу өгүүллүүн:

Ай охин баатар чи гэгээндээ мэд. Би биений үйлдсэн гэмүүдийг цөм мэдэн. Нарныгэрэл өгүүлдүүн: Гэмээ чи мэдэх бөгөөс ялыг хөнгөнөөр хийтүгэй. Өөрийн нөхдөдөө өгүүлдүүн: Энэ муу хүнийг хөвтүүлж ташуур авчир хэмээн өгүүлэв. Сая элдээ гэхэд Нарныгэрэл эртэхийг санаж нулимсаа хоёр нүд дүүрэн асгаруулж ийн өгүүлдүүн: Ай муу хүмүүн бос гэж Нарныгэрэл ийн өгүүлэв. Үнэнийг өгүүлэгч босоод ичингүйрч суув. Төдий Нарныгэрэл сууринаасаа босон ирж, эр юүгээн гар барьж хөтлөн хойд гэрт эчиж оров. Ороод сац Тоонолжингоог ирүүлж мөн төд эм болгож, эр эм гурвуул нөхцөн ханилан жаргавай. Түүний хойно Нарныгэрэл ийн сэтгэрүүн: Миний бие эм хүн буюу, хаан төрийг барих ёсон үгүй бөлгөө. Миний энэ цол, эзний алтан тамгыг миний эрд өгвөөс ямар хэмээн эр эм гурвуул зөвшөөж хаанд айлтгав. Хаан түшмэд тэргүүлэн зөвшөөн соёрхов. Нарныгэрэл бас Лүүгүг үлдсэн, охидыг тэвчсэн, Үнэнийг өгүүлэгчээр эр юүгээ хийсэн, Тоонолжингоог төд мөн эм хийсэн шалтгааныг дэлгэрэнгүйсэ хаанд айлтгав. Хаан бас зөвшөөн соёрхов. Түүний хойно Үнэнийг өгүүлэгч хааны дээд төрийг тавин жил болтол сууж цав үгүй болсон буюу. Жин улсын хаан Үнэнийг өгүүлэгчийг ирүүлж зарлиг болруун:

Ай тавин жил болтол хир үгүй явсан  
 Ашдын их төрийг бэх болгож бүрүүн  
 Насандаа хүрэв чи  
 Өөрийн төрсөн газартаа  
 Өөд болму гэж зарлиг болов

Төдий Үнэнийг өгүүлэгч хааны зарлигийг сонсоод есөн үе мөргөж, өөрийн төрсөн газартаа хариад, сац хоншим бодисаны хийд сүм босгож, эцэг эхийн ясан дээр бас Жэү өвгөний хойд үрийг их ноён болгож ач хариулав. Бас засгийн гэр хадгалсан өвгөн эмгэний хойд үрийг их ноён болгож ач хариулав. Тийн яван атал Нарныгэрэл Үнэнийг өгүүлэгчид өгүүлдүүн:

Алимны ёроол ургасан өвс  
 Адгуусны аманд орохуйяа их гэлээ  
 Асар хураасан эл эд таваарыг  
 Амь арилжихын цагт юун тус.

Төрөхдөө охин хөвүүн хэмээн нэрийдэв. Эдүгээ өвгөн эмгэн болов, бид. Залуу идэр цагаас өнгөрч эдүгээ өтлөв. Үүнээс

улмаар үхэх мэдээ үгүй. Бид гурвуул энэ жаргалдаа ташуурч суусаар хойд заяанд тус үл болмуй за. Хутагт Анандын хувилгаан хар титэмт гармад хүрч, хувьтайяа тойн болвоос ямар хэмээвээс Үнэнийг өгүүлэгч зөвшөөн өгүүллүүн: Эрдэнэ мэт дагина чиний зоригоор болтугай. Тойн болох учирт мэдэл үгүй даган баясалцмуй би хэмээвээс бас Тоонолжингоо хэлэв: Би бас дагалцъя хэмээгээд гурвуул явахыг завдсанд төдий Жин улсын хаанаас таван зуун заан авч, эд таваар эрдэнэ бүгдийг ачиж, таван мянган нөхдийг дагуулж, Анандын хувилгааны зүг залбирч, маань уншиж явав.

Алжаал үгүй уулын хавцгай гэтэлж  
Ариун хар титэмт гармад хүрээд

эрдэнэ, эд таваараа барьж мөргөөд нэгэн этгээдэд суун өгүүллүүн:

Хамаг баясгалангийн хувилгаан чи  
Хамаг амьтны тусын тулд асран бясалгахад  
Харанхуй сансарт зорчихуй биднийг  
Хайрлаж тойн болго хэмээн өчсөнд гарма тэдний

сүсгийг мэдээд, хэтэрхий дээд мандлыг үүсгэж найман гишүүт бацчуудыг гийгүүлэн бүрнээр соёрхов. Үнэнийг өгүүлэгч аршийн хутгийг олов. Нарныгэрэл Тоонолжингоо хоёул дагины хутгийг олов. Таван мянган хүн ариун сэтгэл үүсэлдвэй. Таван зуун заан сухабадийн оронд хүний төрлийг олов. Үнэнийг өгүүлэгч, Нарныгэрэл, Тоонолжингоо гурвуулын эцэг, эх Жэу өвгөн эмгэн, засгийн гэр хадгалсан өвгөн эмгэн бүгдээр тонилж, сухабадийн оронд төрөв. Үнэнийг өгүүлэгч эр эм гурвуул тойн болсон наймдугаар зүйл.

\* \* \*

Жич Үнэнийг өгүүлэгч Тойн болж Гармагийн хийдийг түмэн үе эргэж, есөн мянган үе мөргөөд харивай. Тэнд будлан ууланд очиж, аръяабал дугаа уулзаж мөргөөд, аршийн хутгийг олов. Нарныгэрэл, Тоонолжингоотон дагинасын хутгийг олов. Үнэнийг өгүүлэгчийн үр ач зуун үед хүртэл жаргаад, номоор дэлгэрч, тариа төмс төрж, амгалаанаар жарган суув.



### Тайлбар

Энэ тууж болбоос Цагаан дар эхийн тууж, Үнэнийг өгүүлэгч Нарныгэрэл дагины тууж, Тоонолжингоо дагины тууж хэмээх зэрэг олон янзын нэртэй явдаг бөгөөд шийтэд түгээмэл дэлгэрсэн тууж болмуй. Энэ зохиол ер хэвлэгдсэнгүй боллолтой. Хятад, эиэтхэгийн зарим нэгэн туужийг дууриалган монгол хүн зохиосон боловч уу гэж санамаар баймуй. Гэвч үүнийг сайн судлаагүй тул ямар ч шийдвэртэй үг хэлэх аргагүй баймуй. Надад олдсон Нарныгэрэл дагины туужийг үзвээс хулсан үзгээр бичсэн бөгөөд бичгийн хэлбэр нь арван долдугаар зуунаас өмнөх үеийн бичиг мэт. Тус туужийг өөртөө байгаа хулсан үзгийн эхээс яг хэвээр хуулж аваад Ленинградын дорно дахиныг судлах газрын номын санд байгаа бичмэл судартай тулгаж засаад хэвлэвэй... хэмээн эрдэмтэн зохиолч Цэндийн Дамдинсүрэн гуай бичсэн байна.

### Зарим үгийн тайлбар

1. Жин улс — Зөрчидийн Алтан улс
2. Сартваахи — Худалдаачны ноён, далайгаар аялагч худалдаачдын жингийн тэргүүн, зам удирдагч, тэргүүн худалдаачин г.м утгатай үг.
3. Гилбэлгээн — аянгын цахилгаан, гялбаа
4. Ойгоо төөрсөн — ой ухаан төөрч мунгинасан
5. Мунасан — мунгинасан, зөнөсөн
6. Халхай их ноён — ханагар их ноён, түмний ноён
7. Хөвөө мэргүй — хөгшин хөвөө, өгөл зөнөг, болхи тэнэг, (мэргүү) эргүү мэргүү

8. Өвчин... энэгдэв — өвчин... нэмэгдэв, улам энэлэв, энэл-гэгдэв.
9. Эрүүлэх, эрүүт — яллах, ялт гэсэн үг
10. Алимад — аливаа
11. Ягша — шулмас
12. Багир (бигир) — бөөн, цул г.м утгатай
13. Лоо — шорон. Манжаар мөн лоо гэдэг
14. Синнэхү — шалгуулах. Манжаар симнэрэ гэдгийг ингэж хэлжээ,
15. Чив болгосон: Цэвдэг хүйтэн, жихүүн ширүүн болгосон
16. Хонтож — хонжиж
17. Үлдсэн — хөөж туусан
18. Тай — тавцан, цамхаг, индэр хотон г.м. олон утгатай
19. Алжаас үгүй — гэм буруу, алдас нүгэлгүй
20. Авшиг — рашаан, угаал ариулга
21. Тэвчих — цаазлах



## ЦАГААН ДАР ЭХИЙН ТУУЖ

Монгол бичгээс кириллд буулгасан  
Цэрэндоржийн Сүхбаатар  
Хянал тохиолдуулсан  
Готовьи Нямаа, Гүндүүгийн Булитогтох  
Хянагч  
Д. Сугар, Е. Үнэн  
Уран сайхны редактор, зураач  
Дашзэвэгийн Батсуурь